

ARNCLIFFE WEST INFANTS PRESCHOOL



ЦЭЦЭРЛЭГИЙН ТАНИЛЦУУЛГА 2024

7 Loftus St
Arnccliffe
2205

Phone:
9567 7062

Grow in Friendship



ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ АЖИЛЧИД



Bryce Hageman

- * Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- * Шилэгдмэл удирдагч
- * Боловсролын тэргүүлэгч
- * Хариуцлагатай ажилтан



Tina Andrews

- * Сурган хүмүүжүүлэгч/ Багш



Salwa Bazzi

- *Сурган хүмүүжүүлэгч/ Туслах багш



Jacquie Munkhbayar

- *Туслах багш

БИДНИЙ ЗАРЧИМ

Арнклиф Вэст Инфантс сургууль нь сургуулийн өмнөх насны хүүхдүүд, тэдгээрийн гэр бүлийн хувьд найрсаг нөхөрсөг, аюулгүй тайван сургалтын орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Амар тайван, идэвхтэй, эрч хүчээр дүүрэн сургалтын орчин нь хүүхдийн оюун санааг хөгжүүлж, идэвхжүүлэхэд чухал нөлөөтэй гэж бид үздэг. Мөн бид хүүхдийг өөртөө итгэлтэй бие хүн болж төлөвших явцыг нь дэмжих үүднээс тэднийг үргэлж хүндэлж, урамшуулж, сорьж байдаг.

Бид “тоглоомд суурилсан сургалт”-н аргыг баримталдаг бөгөөд хүүхдүүд өөрсдөө мэдлэгийг бүтээж харин багш нар зөвхөн чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг гэж бид итгэдэг. Хичээлийн суурь хөтөлбөр боловсруулах, хүүхдийн талаар гэр бүлтэй нь хэлэлцэхэд бид ‘Сургуулийн Өмнөх Боловсролын сургалтын хөтөлбөр’-г баримталдаг. Хүүхдүүд өөрийн мөн чанарын талаар гүн ойлголттой болж, өөрсдийн дотоод ертөнцтэй холбогдож, түүндээ хувь нэмэр оруулж суралцах, мөн өөртөө итгэлтэй, идэвхтэй суралцагчид болж, бусадтай амжилттай харилцах чадвартай болж төлөвшдөг.

Манай сургууль бүтээлч урлаг, дуу хөгжим, жүжиг, дүрслэх урлаг, технологи, байгаль орчин, авхаалж самбаа болон мэдрэхүй хөгжүүлэх тоглоом наадгай, математик болон бичиг үсгийн боловсролд чиглэсэн сургалтуудыг сургуулийн дотоод анги танхим болон гадаад орчинд амжилттай зохион байгуулсаар ирсэн. Эдгээр сургалтын орчин нь хүүхдэд цогц боловсрол олгохоос гадна тэдний сонирхлыг тал бүрээс нь хөгжүүлж мөн соёлын өвийг хадгалахад чиглэсэн байдаг.

Манай сургалтын хөтөлбөрүүд хүүхдэд тухайн орчинд өгөгдсөн сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглан чөлөөт тоглоомын аргаар аливааг өөрийн сонирхлоор нээн илрүүлэх, бие даасан байдлыг хөгжүүлэхэд тусладаг. Сургалтын хэрэглэгдэхүүнүүд нь хүүхэд бүрийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн бөгөөд хүүхдийн сониуч занг нь хөгжүүлж өгдөг. Мөн бид ухаалаг самбар болон АйПад ашиглах замаар сүүлийн үеийн технологийг сургалтын орчиндоо нэвтрүүлэн ажиллаж байна.

ЦЭЦЭРЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ: 9:30 - 15:30 /хичээлийн улиралд/

Бид өглөөний 9:30-д нээж аюулгүй байдлын үүднээс 10:30-д хаалгаа барина. Хэрэв та 10:30-с хойш ирсэн бол манай оффис руу залгаж цэцэрлэгийн ажилтантай холбогдон дотогш нэвтрэх хүсэлтээ илэрхийлнэ үү.


Цэцэрлэгийн хаалга 14:30-д нээгдэж 15:30-д хаалгаа барина. Харин та хүүхдээ 15:30-с өмнө авч амжаагүй тохиолдолд том сургуулийн төв оффисоос хүүхдээ ирж аваарай. Мөн та хүүхдээ хоцорч авахаар бол оффис руу утасдаж мэдэгдэх эсвэл цагаас нь өмнө авах тухайгаа манай ажилтанд урьдчилан мэдэгдэнэ үү.

Хүүхдийг эцэг эх нь эсвэл 18 наснаас дээш насны хүн цэцэрлэгт хүргэж өгч авна. Мөн хүүхдийг хүргэж өгч авч буй хүн гарын үсгээ зурж баталгаажуулна. Хэрэв эцэг эхээс өөр хүн хүүхдийг авахаар бол бидэнд 15:30-с өмнө урьдчилан мэдэгдэнэ үү. Мөн тухайн хүн өөрийн биеийн байцаалтыг манай ажилтанд шалгуулж хүүхдийг авах боломжтой.

Австралийн засгийн газрын Сургуулийн Өмнөх Боловсролын журмын дагуу манай цэцэрлэгийн ангиуд хоёр долоо хоногт 5 өдөр хичээллэдэг. Анги тус бүр нэг долоо хоногт 2-3 өдөр ээлжлэн хичээллэнэ.

Манай цэцэрлэг эцэг эхчүүдэд үргэлж нээлттэй байдаг. Харин та сургуулийн орчинд нэвтрэх болон зочлоход QR код ашиглан бүртгүүлэхийг анхаарна уу.

УЛИРАЛ БҮРИЙН ЭХЭНД АНГИУДЫН ХУВААРИЙГ ТЭМДЭГЛЭСЭН КАЛЕНДАРЫГ ТАНЬД ОЛГОНО.



Коала: 1-р долоо хоног - Даваа, Мягмар, Лхагва
2-р долоо хоног - Даваа, Мягмар



Фоссум: 1-р долоо хоног- Пүрэв, Баасан
2-р долоо хоног- Лхагва, Пүрэв, Баасан

Төлбөр:

Эцэг эхчүүд цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүний төлбөр 50\$-г улирал бүр сайн дураар сургуульд төлнө.

Хэрэв та хүүхдээ Арнклиф Вэст Инфантс цэцэрлэгээс гаргах шийдвэр гаргасан бол бидэнд 4 долоон хоногийн өмнө мэдэгдэх шаардлагатай.

Австралийн Сургуулийн Өмнөх Боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго



Сургалтын үр дүн 1:
Хүүхэд бие хүн болж
төлөвшинө.




Сургалтын үр дүн 2:
Хүүхэд хүрээлэг буй
орчинтой холбогдож
өөрийн хувь нэмрээ
оруулж сурна.



Сургалтын үр дүн 3:
Хүүхэд эрүүл амьдралын
талаар ойлголттой болно.



Сургалтын үр дүн 4:
Хүүхэд өөртөө итгэлтэй
идвэхитэй суралцагч
болно.



Сургалтын үр дүн 5:
Хүүхэд үр дүнтэй
харилцаж сурна.



Цэцэрлэг эхлэхийн өмнөх бэлтгэл:

Та хүүхдээ цэцэрлэгт явуулахын өмнө цэцэрлэг ямар байх талаар хүүхэдтэйгээ харилцан ярилцаарай. Жишээ нь: цэцэрлэгт явах тухай түүх уншиж өгөх, цэцэрлэгт хийж болох зүйлсийн тухай ярилцах, шинэ найз нөхөдтэй болох гэх мэт.

Авчрах шаардлагатай зүйлс:

Өдөр бүр таны хүүхдийн цүнхэнд дараах зүйлс байх шаардлагатай.

- Өдрийн эрүүл хоол
- Өглөө болон өдрийн жимс (жимсийг тусдаа саванд хийх)
- Савтай ус

Та хүүхдийнхээ хоол, жимс болон усны саван дээр нэрийг нь харагдахуйц тод байдлаар бичиж тэмдэглэнэ үү.

Хувцаслалт:

Хүүхэд цэцэрлэгт ирэхдээ тав тухтай бөгөөд нарнаас хамгаалах хувцас өмсөх, өөрөө бие даан өмсөхөд тохиромжтой гутал өмссөн байхыг анхаарна уу. Усан будаг, цавуу ашиглах, элсэн дээр тоглох зэргээс хүүхдийн хувцас амар бохирддог тул эдгээрийг харгалзан үзэж тохиромжтой хувцсыг хүүхэддээ өмсүүлэхийг зөвлөж байна. Мөн хүүхдийнхээ хувцсан дээр нэрийг нь бичиж таних тэмдэглэгээ хийнэ үү.

Улирал бүрийн эхэнд хүүхдийнхээ солих хувцсыг бэлдэж авчраарай. Эдгээр хувцаснуудыг сургууль дээр хадгалах бөгөөд шаардлагатай тохиолдолд хүүхдэд сольж өмсүүлнэ.

Нарны хамгаалалт:

Сургуулиас хүүхэд тус бүрт гадаа тоглоход өмсөх нарнаас хамгаалах зориулалт бүхий нарны малгайг өгдөг. Харин та хүүхэддээ жижиг хэмжээтэй хувийн хэрэглээнд тохиромжтой нарны тосыг нэрийг нь бичин өгч явуулаарай. Энэхүү нарны тос нь сургууль дээр үлдэнэ. Мөн эцэг эхчүүд хүүхдээ цэцэрлэгт ирэхэд нь нарны тос түрхсэн байхыг зөвлөж байна.

Хоол:

Өдрийн хоол хүүхэд бие даан идэхэд тохиромжтой, эрүүл байх шаардлагатай. Өдрийн хоолонд салат, сэндвич, ороомог, гоймон, паста салат, шарсан хуурга, мах, бяслаг, болгосон шош, тараг, ногооны төрлөөс тухайлбал лууван, өргөст хэмх; жимсний төрлөөс тухайлбал усан үзэм, хатаасан жимс, бага хэмжээний лаазалсан жимс зэрэг байж болно.

Бид хүүхдүүдийн өдрийн хоолыг хөргөгчинд хадгалдаггүй тул өдрийн хоолны саванд нь мөс хийхийг зөвлөж байна. Мөн бид хүүхдүүдийн өдрийн хоолыг халаах боломжгүй болно.



ӨДӨР ТУТМЫН ЭРҮҮЛ ХООЛНЫ СОНГОЛТУУД



Бусад мэдээлэл:

Шагнал урамшуулал: Долоо хоног бүр амжилттай суралцсан хүүхдүүдэд баярын бичиг олгодог. Нийт 5 баярын бичгээр шагнагдсан тохиолдолд сургуулийн захирлын нэрэмжит номын шагнал авах эрхтэй болно.



Өвчин: Хэрэв хүүхэд тань өвдсөн бол бусад хүүхэд болон багш ажилчдад халдахаас урьдчилан сэргийлэх үүднээс цэцэрлэгт нь бүү явуулаарай. Хүүхдэд ямар нэг өвчин эсвэл КОВИД-19 шинж тэмдэг илэрвэл бид эцэг эх, асран хамгаалагчтай нь холбогдож хүүхдээ ирж авах хүсэлт тавих болно.

Хэрэв хүүхэд тань салхин цэцэг, КОВИД-19 зэрэг халдварт өвчин туссан бол бидэнд яаралтай мэдэгдэнэ үү. Халдварт өвчний хорио цээрийн тогтсон хугацааг таны хүүхэд болон бусад хүүхдүүд дагаж мөрдөнө. (Хуудас 14/15-с дэлгэрэнгүй мэдээллийг авна үү.)

Сургуулийн зөвлөх үйлчилгээ: Бид сургуулийн зөвлөх ажилтантай хамтран ажилладаг бөгөөд таны хүүхдэд ямар нэг нэмэлт тусламж шаардлагатай бол бидэнтэй холбогдоорой. Мөн таньд лавлагаа (referral) хэрэгтэй бол бидэнд хандна уу.

Харилцаа холбоо: Цэцэрлэгийн үүдний танхим дахь харилцах самбарт байрлах сургуулийн мэдээ, төлбөрийн баримт болон бусад мэдээллүүдийг тогтмол шалгаж байхыг эцэг эхчүүдэд зөвлөж байна. Мөн та сургуулийн үйл ажиллагаа, чухал мэдээлэл зэргийг цаг тухайд нь хүлээж авахыг хүсвэл Скуул Байтс (School Bytes) аппликэйшнийг татаж аваарай. Аппликэйшн татаж авах зааврыг 13-р хуудаснаас харна уу. Мөн сургуулийн мэдээг эцэг эхчүүд рүү имэйлээр тогтмол явуулах болно.

Гэрийн хаяг, утасны дугаарын өөрчлөлт: Хэрэв таны гэрийн хаяг, утасны дугаар өөрчлөгдсөн бол манай ажилчдад цаг алдалгүй мэдэгдэнэ үү.

Вакцинжуулалт: Та хүүхдээ цэцэрлэгт бүртгүүлэхдээ вакцинд хамрагдсан бичгийн хуулбарыг авчирч өгнө үү. 2018 оны 1 сарын 1-с эхлэн хувийн үзэл бодлын улмаас хүүхдээ вакцинд хамруулаагүй тохиолдолд хүүхдийг сургуульд элсүүлэх боломжгүй болсон гэдгийг анхаарна уу. Мөн хүүхэд тань 4 нас хүрэх үед шинэчилсэн вакцины бичиг шаардагдана.

Скуул Байтс (School Bytes): Скуул Байтс нь эцэг эхчүүдэд зориулсан портал бөгөөд уг порталыг ашиглан онлайнаар төлбөр хийх, төлбөрийн баримт татаж авах, зөвшөөрлийн бичигт дижиталаар гарын үсэг зурах, хүүхдэд урьдчилан чөлөө авах, хичээлд ирэхгүй тохиолдолд тайлбар бичиж илгээх, шаардлагатай тохиолдолд форм бөглөх боломжтой. Уг порталд хэрхэн бүртгүүлэх талаар 12 болон 13 дугаар хуудаснаас харна уу.

Эцэг эхийн хамтын ажиллагаа: Эцэг эхчүүд хичээлийн жилийн турш зохиогдох тэмдэглэлт арга хэмжээнд нээлттэй оролцох боломжтой. Мөн сургуулийн эцэг эхийн зөвлөл хичээлийн улирал тутамд хуралдаж тэмдэглэлт үйл ажиллагаа зохион байгуулах, мөнгөн хандив босгох зэргээр хувь нэмрээ оруулдаг. Уг үйл ажиллагаанууд нь эцэг эхчүүд хоорондоо танилцан нөхөрлөх боломжийг олгодог. Мөн бид эцэг эхчүүдийг цэцэрлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг уриалж байна. Хэрэв та сайн дураар оролцохыг хүсвэл хүүхдийнхээ багштай холбогдоорой.

Зөв зан харилцаа



БИД ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

Манай сургууль нь Шинэ Өмнөд Уэльс мужийн Боловсролын Хэлтсийн (NSW Department of Education) удирдлага дор хүүхдүүдэд цэцэрлэгээс авахуулан 2 дугаар анги хүртэлх боловсролыг олгодог улсын сургууль юм. Манай сургуулийн захирал нь дараах хариуцлагат үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Шилэгдмэл удирдагч

Боловсролын тэргүүлэгч

Хариуцлагатай ажилтан

ЗӨВШӨӨРӨЛ БА ЗЭРЭГЛЭЛ

Манай цэцэрлэг өдөр бүрийн 9:30-15:30 хооронд 20 хүртэлх хүүхдийг хүлээн авах зөвшөөрөлтэй бөгөөд нэг багшид 10 хүүхэд ноогддог.

Зөвшөөрөл олгогч байгууллага: Шинэ Өмнөд Уэльс мужийн Боловсролын Хэлтэс (NSW Department of Education) PR-00005345

Зөвшөөрлийн дугаар: SE-00006461

Үйлчилгээний үнэлгээ болон зэрэглэл: 2019 оны 7 дугаар сарын байдлаар үйлчилгээний зэрэглэл тогтоогдсон.

Бид [Education and Care Services National Regulations](#); журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг.

Хэрэв та дээрх журамтай танилцахыг хүсвэл өөрийн хүүхдийн багштай холбогдоно уу.

САНАЛ ГОМДОЛ

Хэрэв таньд ямар нэг санал гомдолтой бол юуны түрүүнд хүүхдийнхээ багшид хандаж уулзахад тохиромжтой цагийг товлорой.

Харин та тухайн асуудлын шийдэлд сэтгэл хангалуун бус байх эсвэл ангийн багшид хандах нь тохиромжгүй гэж үзвэл бидэнтэй утсаар холбогдон сургуулийн захиралтай уулзалт товлон боломжтой.

Таны гаргасан санал гомдлыг бид 'Сургууль ба хэрэглэгчийн санал гомдлыг шийдвэрлэх журам 2017' (School Community and Consumer Complaint Procedure, 2017)-н дагуу чандлан нууцлах болно. Мөн ач холбогдол багатай санал гомдлыг бид албан бусаар шийдвэрлэнэ.

Хэрэв таны гаргасан санал гомдлыг сургуулийн захирлын зүгээс хангалттай шийдвэрлэж чадаагүй гэж үзсэн тохиолдолд та албан ёсны санал гомдлыг доорх байгууллагад хандан гаргах боломжтой.

Early Childhood Education Directorate, NSW Department of Education

Locked Bag 5107, PARRAMATTA NSW 2124

Phone number - 1800 619 113 (toll free)

ececd@det.nsw.edu.au

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Хэрэв таны хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой ямар нэг асуудал үүссэн бол Хүүхэд Хамгааллын дуудлагын төв болох 132111-рүү хандаарай. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.community.nsw.gov.au/home-aac> авна уу.

Хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой аливаа мэдээллийг холбогдох байгууллагад мэдээлэх нь сургуулийн бүх багш ажилчдын хуулиар хүлээсэн зайлшгүй үүрэг юм. Багш ажилчид хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийг сургуулийн захирал эсвэл 'Боловсролын хэлтсийн хүүхэд хамгааллын хэсэг' (Department's Child Wellbeing Unit)-т мэдээлэх үүрэгтэй.

Сургуулийн бэлтгэл хөтөлбөр

Манай цэцэрлэг нь улсын сургуульд харъяалагддагаараа онцлог бөгөөд энэ нь хүүхдүүдэд ахлах сургуульд шилжин суралцахад шаардлагатай үр чадварыг эзэмшүүлэх боломжийг олгодог давуу талтай.

Хүүхэд цэцэрлэгт суралцаж байх хугацаандаа ‘Сургуулийн бэлтгэл хөтөлбөр’-р дамжуулан дараах хөтөлбөрүүдэд хамрагддаг. Үүнд:

- Номын сангаар үйлчлүүлэх
- Өглөөний ассамблей хурал болон шагнал гардуулах үйл ажиллагаанд оролцох
- Хичээлийн 3 дугаар улирлаас эхлэн үдийн цайны цагаар том сургуультай танилцах, найз нөхөдтэй болох, тоглоомын талбайд тоглох
- Ахлах сургуулийн багш нартай уулзаж танилцах
- Хичээлийн 4 дүгээр улирлаас эхлэн ‘Сургуульд шилжин суралцах’ (Transition-To-School) хөтөлбөрт хамрагдсанаар сургуулийн бэлтгэл ангийн хуваарь, анги танхимтай танилцах

Уг хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд ахлах сургуулийн хуваарьт дасан зохицох чадвартай болж нэг ангийн хамт олонтойгоо амжилттай суралцаж байна.

Манай цэцэрлэг ‘Австралийн Сургуулийн Өмнөх Боловсролын сургалтын хөтөлбөр’ - г өдөр тутмын сургалтанд тусган ажиллаж байна.

BELONGING,
BEING &
BECOMING




The Early Years Learning
Framework for Australia
V2.0, 2022

“Хөтөлбөрийн үндсэн агуулга нь хүүхдийн амьдралын бусадтай холбогдох орчин, ахуй, хүн болох үйл явцыг чухалчилж үздэг. Хүүхэд төрөхөөсөө өмнө гэр бүл, олон нийт, соёл иргэншил болон амьдрах газар оронтойгоо холбогдож эхэлдэг. Тэдний хамгийн анхны сурах, хөгжих үйл явцууд эдгээр харилцаа холбоогоор дамжин явагдаж байдаг. Ялангуяа гэр бүл бол хүүхдийн хөгжил, боловсролд хамгийн чухал нөлөө үзүүлэх суурь хөрс нь болж байдаг. Хүүхэд өдөр тутмын амьдралд оролцох байдлаар өөрсдийн сонирхол, өөрсдийгөө танин мэдэх болон дэлхий ертөнцийн тухай ойлголтуудаа хөгжүүлж өөрсдийн орчин, ахуй, хүн болох үйл явцаа тодорхойлж байдаг.” (Австралийн Сургуулийн Өмнөх Боловсролын сургалтын хөтөлбөр’ V2.0, 2022;

ТӨЛБӨРИЙН ШИНЭЧИЛСЭН СИСТЕМ ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН БОЛЛОО!

Бидний зүгээс эцэг эх, асран хамгаалагч та бүгдэд хэрэглэхэд тохиромжтой, хялбарчилсан төлбөрийн системийг танилцуулахад таатай байна.



Эцэг эхчүүдийн портал

- Төлбөрийг онлайнаар төлөх
- Төлбөрийн баримтаа татаж авах
- Зөвшөөрлийн бичигт дижиталаар гарын үсэг зурж илгээх
- Бүртгэлтэй дансан дахь үлдэгдлээ ашиглан төлбөр хийх
- Төлбөрийн түүхээ харах
- Төлбөр тооцоог буцаах хүсэлт гаргах



School Bytes

Эцэг эхчүүдийн порталд дараах QR кодоор эсвэл доорх холбоосоор орж бүртгүүлнэ үү.

<https://portal.schoolbytes.education>





School Bytes

ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН АПП ТАТАЖ АВАХАД БЭЛЭН БОЛЛОО.

Уг аппликэйшнийг доорх зурган дээр даран App store (iPhone) эсвэл Google Play (Samsung) - с татаж авна уу.



Аппликэйшний давуу талууд:

- Сургуулиас ирж буй мэдээллийг цаг алдалгүй авах
- Өөрийн порталаас гаралгүйгээр картны мэдээллээ хадгалан хүүхдийнхээ аялал зугаалгын хураамж, бусад төлбөр тооцоог амар хялбар хийх
- Зөвшөөрөл өгөх, гарын үсэг зурах, хүүхдийн ирцийн бүртгэлийн сануулгад хариу бичих
- Сургуулийн календар болон мэдээтэй танилцах



Too sick for school?



Generally if your child feels unwell, keep them home from school and consult your doctor. This chart and the information it contains is not intended to take the place of a consultation with your doctor.

Bronchitis	Symptoms are coughing, a runny nose, sore throat and mild fever. The cough is often dry at first, becoming moist after a couple of days. There may be a slight wheeze and shortness of breath. A higher fever (typically above 39°C) may indicate pneumonia.	 ... until they are feeling better. Antibiotics may be needed.
Chickenpox (Varicella)	Slight fever, runny nose, and a rash that begins as raised pink spots that blister and scab.	 ... for 5 days from the onset of the rash and the blisters have dried.
Conjunctivitis	The eye feels 'scratchy', is red and may water. Lids may stick together on waking.	 ... while there is discharge from the eye unless a doctor has diagnosed a non-infectious cause.
Diarrhoea (no organism identified)	Two or more consecutive bowel motions that are looser and more frequent than normal and possibly stomach cramps.	 ... for at least 24 hours after diarrhoea stops.
Fever	A temperature of 38.5°C or more in older infants and children.	 ... until temperature is normal.
Gastroenteritis	A combination of frequent loose or watery stools (diarrhoea), vomiting, fever, stomach cramps, headaches.	 ... for at least 24 hours after diarrhoea and/or vomiting stops.
German measles (Rubella)	Often mild or no symptoms: mild fever, runny nose, swollen nodes, pink blotchy rash that lasts a short time.	 ... for at least 4 days after the rash appears.
Glandular Fever (Mononucleosis, EBV infection)	Symptoms include fever, headache, sore throat, tiredness, swollen nodes.	 ... unless they're feeling unwell.
Hand, Foot and Mouth Disease (HFMD)	Generally a mild illness caused by a virus, perhaps with a fever, blisters around the mouth, on the hands and feet, and perhaps the nappy area in babies.	 ... until all blisters have dried.
Hayfever (Allergic rhinitis) caused by allergy to pollen (from grasses, flowers and trees), dust mites, animal fur or hair, mould spores, cigarette smoke	Sneezing, a blocked or runny nose (rhinitis), itchy eyes, nose and throat, headaches.	 ... unless they feel unwell or are taking a medication which makes them sleepy.
Head lice or nits* (Pediculosis)	Itchy scalp, white specks stuck near the base of the hairs; lice may be found on the scalp.	 ... while continuing to treat head lice each night. Tell the school.

Hepatitis A	Often none in young children; sudden onset of fever, loss of appetite, nausea, vomiting, jaundice (yellowing of skin and eyes), dark urine, pale stools.	 ... for 2 weeks after first symptoms (or 1 week after onset of jaundice). Contact your doctor before returning to school.
Hepatitis B	Often no symptoms in young children. When they do occur, they can include fever, loss of appetite, nausea, vomiting, jaundice (yellowing of skin and eyes), dark urine.	 ... if they have symptoms. Contact your doctor before returning to school.  ... if they have a chronic infection (not the first outbreak) and no symptoms.
Impetigo (School sores)	Small red spots change into blisters that fill up with pus and become crusted; usually on the face, hands or scalp.	 ... until antibiotic treatment starts. Sores should be covered with watertight dressings.
Influenza	Sudden onset fever, runny nose, sore throat, cough, muscle aches and headaches.	 ... until well.
Measles	Fever, tiredness, runny nose, cough and sore red eyes for a few days followed by a red blotchy rash that starts on the face and spreads down the body and lasts 4 to 7 days.	 ... for at least 4 days after the rash appears.
Meningococcal Disease	Sudden onset of fever and a combination of headache, neck, stiffness, nausea, vomiting, drowsiness or rash.	Seek medical attention immediately. Patient will need hospital treatment. Close contacts receive antibiotics.
Molluscum Contagiosum	Multiple small lumps (2–5mm) on the skin that are smooth, firm and round, with dimples in the middle. In children, occur mostly on the face, trunk, upper arms and legs. Symptoms can last 6 months to 2 years.	
Mumps	Fever, swollen and tender glands around the jaw.	 ... for 9 days after onset of swelling.
Ringworm* (tinea corporis)	Small scaly patch on the skin surrounded by a pink ring.	 ... for 24 hours after fungal treatment has begun.
Runny nose or common cold		 ... unless there are other symptoms such as fever, sore throat, cough, rash or headache. Check with school.
Scabies*	Itchy skin, worse at night. Worse around wrists, armpits, buttocks, groin and between fingers and toes.	 ... until 24 hours after treatment has begun.
Shigella	Diarrhoea (which may contain blood, mucus and pus), fever, stomach cramps, nausea and vomiting.	 ... until there has not been a loose bowel motion for 24 hours. Antibiotics may be needed.
Slapped Cheek Syndrome (Parvovirus B19 infection, fifth disease, erythema infectiosum)	Mild fever, red cheeks, itchy lace-like rash, and possibly cough, sore throat or runny nose.	 ... as it is most infectious before the rash appears.
Whooping Cough (Pertussis)	Starts with a running nose, followed by persistent cough that comes in bouts. Bouts may be followed by vomiting and a whooping sound as the child gasps for air.	 ... until the first 5 days of an antibiotic course has been completed. Unimmunised siblings may need to stay home too until treated with an antibiotic.
Worms (Threadworms, pinworms)	The main sign of threadworms is an itchy bottom. Sometimes children feel 'out of sorts' and do not want to eat much. They may also have trouble sleeping, due to itching at night.	 ... and tell the school as other parents will need to know to check their kids.

***It is important that the rest of the family is checked for head lice, scabies and ringworm**



Information provided by NSW Health.

© Owned by State of NSW through the Department of Education and Communities 2012. This work may be freely reproduced and distributed for non-commercial educational purposes only. Permission must be received from the department for all other uses.

2/2

МАНАЙ СУРГУУЛЬД ТАВТАЙ МОРИЛЖ ХӨГЖИЛТЭЙ ЦАГИЙГ ӨНГӨРҮҮЛЭЭРЭЙ!



Боловсролын хэлтсээс орчуулагдсан бусад эх сурвалж материалуудыг
Доорх холбоосоор орж харна уу.
education.nsw.gov.au/back-to-school